

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**Орхон аймгийн Хүүхэд залуучуудын театрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн хураангуй тайлан**

Аудитын код: ОРА-2023/64/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Эрдэнэт хот 2023 он	Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Нармандах Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn Аудитын менежер: Б.Буян-Ундрах Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn Аудитор: Б.Азжаргал Утас: 70357955 Цахим хаяг: azjargalb@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2023.08.14 № 09

танай _____-ны № _____-т

ОРХОН АЙМГИЙН ХҮҮХЭД,
ЗАЛУУЧУУДЫН ТЕАТРЫН
ЗАХИРАЛ Х.ХИШИГБААТАР
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Хүүхэд, залуучуудын театрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн Хүүхэд, залуучуудын театрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Орхон аймгийн Хүүхэд, залуучуудын театр санхүүгийн тайланд тодруулж тайлагнасан, тооцооны үлдэгдлийн баталгаагаар баталгаажаагүй 1999 оноос өмнөх дуу бүжгийн Эрдэнэт чуулга, 13 иргэн, албан байгууллагатай холбоотой 2,600.0 мянган төгрөгийн авлагатай бөгөөд хуулийн байгууллагад хандах нотлох баримт бүрдүүлэхэд хүндрэл үүссэн, шийдвэрлүүлээгүй өнөөг хүрсэн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна. Анхан шатны баримтын бүрдэл хангах, түүнд хяналт хэрэгжүүлсэн байдал нь үр нөлөөгүй байгаа нь гүйцэтгэлийн үе шатанд хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнд илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэлээр илэрч байна.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Орхон аймгийн Хүүхэд, залуучуудын театр нь 2022 оны төсвийн жилд Боловсрол, шинжлэх ухааны яамны сайдын багцаас Соёлын яамны сайдын багцад шилжсэн байна. Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй төрийн аудитын албан хаагчид аливаа этгээдийн нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

	Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	176,866,174.69	281,245,637.69
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	988,131,728.80	946,502,472.47
	Нийт хөрөнгийн дүн	1,164,997,903.49	1,227,748,110.16
	Нийт өр төлбөрийн дүн	1,164,997,903.49	1,227,748,110.16
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,164,997,903.49	1,227,748,110.16
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,164,997,903.49	1,227,748,110.16
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	559,678,620.00	765,120,097.00
	Үйл ажиллагааны зардлын дүн	596,226,223.25	702,438,975.83
	Үйл ажиллагааны үр дүн	(36,547,603.25)	62,681,121.17
	Үйл ажиллагааны бус үр дүн	(36,547,603.25)	62,681,121.17
	Үйл ажиллагааны нийт үр дүн	(36,547,603.25)	62,681,121.17
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	484,196,483.11	1,164,997,903.49
	Тайлант оны үр дүн	0	62,681,121.17
	Эцсийн үлдэгдэл	484,196,483.11	1,227,679,024.66
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	559,700,165.00	726,005,052.00
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	560,350,165.00	642,645,553.28
	Үйл ажиллагааны ЦМГ	(650,000.00)	83,359,498.72
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	0	0
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	(650,000.00)	83,359,498.72
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	(650,000.00)	83,359,498.72
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	25,000.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	725,000.00	56,360,505.72
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн		629,362,803.28
	Урсгал зардал		629,362,803.28
	Хөрөнгийн зардал		0
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		0
	Улсын төсвөөс санхүүжих		557,447,003.28
	Орон нутгийн төсвөөс		71,915,800.00

Гурав. Аудитын илрүүлэлт

3.1 Төлбөрийн акт: Байхгүй

3.2 Албан шаардлага

Илрүүлэлт: "Асаж буй толгод" жүжиг тайзанд тавихад шаардагдах 19,293,000 төгрөгийн бараа материал нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа хуулийн дагуу шалгаруулаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.2-д "батлагдсан төсөв хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14

дүгээр зүйлийн 14.1-д “төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ”, 14.4-д “цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно”, 14.5-д “төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар зарлана” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Илрүүлэлт: Эмчилгээний зардалд 400,000 төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.2-д “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, Хүүхэд залуучуудын театрын дотоод журмын 10.3-д “байгууллагаас өндөр насны тэтгэвэрт гарсан ахмад настан удаан хугацаагаар эмчилгээ сувилгаа хийлгэх, нас барсан тохиолдолд 100,000 төгрөгийн буцалтгүй тусламж олгох” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

3.3 Зөвлөмж

Илрүүлэлт: Тус газарт тайз засалч ажилтай Р.Гансүхийн 2021 оны хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг 2022 онд олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 7.1-д “Төсвийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно”, 7.6-д “Төсвийн жил эхлэхэд төсвийн захирагчийн тухайн төсвийн жилийн батлагдсан төсвийг зарцуулах эрх нь нээгдэнэ”, 16.5.2-д “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, НББ-ийн тухай хуулийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ажилчидтай хийх тооцоог төсвийн жилд багтаан хийж гүйцэтгэх

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Орхон аймгийн Хүүхэд залуучуудын театр					2	19,693.0	1	63.0				
Дүн					2	19,693.0	1	63.0				

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагталзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	Орхон аймгийн Хүүхэд залуучуудын театр	1	1			1			
	НИЙТ	1	1			1			